

# "ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 04 сарын 26 өдөр

Дугаар № 01

Улаанбаатар хот

Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон  
санхүүгийн тайланд өгсөн Төлөөлөн удирдах  
зөвлөлийн дүгнэлтийг батлах тухай


Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9, 62.1.15 дахь заалтыг  
үндэслэн ТОГТООХ нь:

1. "Дорнод бүсийн эрчим хүчний систем" төрийн өмчит хувьцаат компанийн  
2021 оны үйл ажиллагааг "Хангалттай" гэж үнэлсэн Төлөөлөн удирдах  
зөвлөлийн дүгнэлтийг зүйтэй гэж үзсүгэй.

2. Компанийн 2021 оны үйл ажиллагаанд дүгнэлт хийж, зорилтот түвшинг  
биелүүлэх, өртөг зардлыг бууруулах, үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэх,  
санхүү, төлбөрийн чадварыг сайжруулах, аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх  
шаардлагатай арга хэмжээг авч ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга  
(Ж.Жанарбаатар)-д даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН  
ТӨЛӨӨЛӨГЧ


ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМЫГ  
ТӨЛӨӨЛЖ:



Б.НАСАНТОГТОХ



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫГ  
ТӨЛӨӨЛЖ:



Ц.БАЯР-ЭРДЭНЭ



# "ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 04 сарын 26 өдөр

Дугаар № 02

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөл болон аудитын хорооны  
2021 оны ажлын тайлангийн тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.15 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. "Дорнод бүсийн эрчим хүчний систем" төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөл болон аудитын хорооны 2021 оны үйл ажиллагааг "Хангалттай" гэж үзсүгэй.

2. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэн компанийн өмнө тавигдсан зорилтыг ханган биелүүлэх, өр авлагыг барагдуулах, бараа, ажил үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааг хуулийн дагуу явуулах, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд хариуцлагатай, үр дүнтэй, санаачилгатай байхыг тухай бүр нь анхааруулж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл (Ж.Жанарбаатар)-д даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН  
ТӨЛӨӨЛӨГЧ

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМЫГ  
ТӨЛӨӨЛЖ:

  
Б. НАСАНТОГТОХ  
УХА0558

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫГ  
ТӨЛӨӨЛЖ:

  
Ц. БАЯР-ЭРДЭНЭ  
1110209

# "ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 04 сарын 26 өдөр

Дугаар № 03

Улаанбаатар хот

2021 оны ногдол ашгийн тухай

Монгол Улсын Их хурлын 2021 оны 88 дугаары тогтоолын 1.1 дэх заалт, Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.6, 47.1.1, 62.1.15 дахь заалтыг тус тус үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас ТОГТООХ нь:

1. "Дорнод бүсийн эрчим хүчний систем" төрийн өмчит хувьцаат компанийн 2021 оны аудитлагдсан санхүүгийн тайлан тэнцлээр 688,385,135.49 /зургаан зуун наян найман сая гурван зуун наян таван мянга нэг зуун гучин таван төгрөг дөчин есөн мөнгө/ төгрөгийн цэвэр ашигтай ажилласан тул ногдол ашиг 50 хувиар тооцож улсын төсөвт төвлөрүүлэхийг гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН  
ТӨЛӨӨЛӨГЧ

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМЫГ  
ТӨЛӨӨЛЖ:

Б.НАСАНТОГТОХ



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫГ  
ТӨЛӨӨЛЖ:

Ц.БАЯР-ӨРДЭНЭ



# "ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 04 сарын 26 өдөр

Дугаар № 04

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны  
зардлын төсөв батлах тухай

"Компанийн тухай хууль"-ийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалтыг  
үндэслэн ТОГТООХ нь:

1. "Дорнод бүсийн эрчим хүчний систем" төрийн өмчит хувьцаат  
компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны зардлын төсвийг  
хавсралтын дагуу баталсугай.

2. Батлагдсан төсвийн зарцуулалтанд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн  
удирдах зөвлөлийн дэргэдэх Цалин урамшууллын болон Аудитын хороонд тус  
тус даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН  
ТӨЛӨӨЛӨГЧ

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМЫГ  
ТӨЛӨӨЛЖ:

*Б. Насантогтох*

Б.НАСАНТОГТОХ

УХА0559

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫГ  
ТӨЛӨӨЛЖ:

*Ц. Баяр-Эрдэнэ*

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

1118282533

“ДБЭХС” ТӨХК-ийн хувьцаа эзэмшигчдийн  
хурлын 2022 оны 4 дүгээр сарын 28-ны  
өдрийн 09 дугаар тогтоолын хавсралт



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
2022 ОНЫ ЗАРДЛЫН ТӨСӨВ

д/д	Зардлын үзүүлэлт	2022 төлөвлөгөө			
		Хүн	цалин	Сард /мян.төг/	Жилд /мян.төг/
1	<b>1. Цалингийн зардал</b>	<b>10</b>		<b>5,520.0</b>	<b>83,400.0</b>
1.2	ТУЗ-ын дарга	1	750,000	750.0	9,000.0
1.3	Гишүүд	8	700,000	5,600.0	67,200.0
1.4	Нарийн бичгийн дарга	1	600,000	600.0	7,200.0
2	<b>2. НДШимтгэл</b>			<b>1753.485</b>	<b>12,093.0</b>
3	<b>3. Томилолтын зардал</b>				<b>6,564.6</b>
3.1	Унаа	9	214,700	1,932.3	3,864.6
3.2	Байр, хоол /хүн-хоног/	9	50,000	1,350.0	2,700.0
4	<b>4. Бичиг хэрэг</b>			<b>12,000.0</b>	<b>180.0</b>
4.1	Бичиг хэрэг			15.00	180.00
5	<b>5. Хурлын зардал</b>			55.00	660.00
	<b>ДҮН</b>			<b>8,574.8</b>	<b>102,897.6</b>

# "ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 04 сарын 26 өдөр

Дугаар № 05

Улаанбаатар хот

## Гүйцэтгэх захирлын контрактыг дүгнэх тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.15, 84 дүгээр зүйлийн 84.4.2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 345 дугаар тогтоолын 1.1, 2.1 дэх хэсэг, Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан "Гүйцэтгэх захиралтай байгуулсан контрактыг дүгнэх, урамшуулал олгох түр журам"-ын 2.6, 2.7, 2.8, 2.9, 3.4 дэх хэсэг, Эрчим хүчний сайдын 2022 оны А/77 тушаалаар томилогдсон Ажлын хэсгийн дүгнэлтийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн дүрмийн 8.11.5, 8.11.6 дахь заалт, гүйцэтгэх захиралтай байгуулсан контрактын 3.1, 3.2 дахь хэсгийг хэрэгжүүлж ажилласан тул "Дорнод бүсийн эрчим хүчний систем" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирлын 2021 оны контрактын биелэлтийг "Хангалттай" гэж дүгнэсүгэй.

2. Гүйцэтгэх захиралтай онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээг 1 /нэг/ жилийн хугацаатайгаар хөдөлмөрийн тухай хуульд нийцүүлэн шинэчлэн байгуулахыг Төлөөлөн удирдах зөвлөл (Ж.Жанарбаатар)-д удирдамж болгосугай.

3. Засгийн газраас дэвшүүлсэн хэмнэлтийн бодлогод нийцүүлэн өртөг зардлыг бууруулах, дулаан, цахилгааны эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн орлогын төлөвлөгөөг биелүүлэх, өр, авлагыг барагдуулах, үр ашгийг дээшлүүлэх, талаар удирдлага зохион байгуулалтын бодитой арга хэмжээ авч ажиллахыг гүйцэтгэх захирал /Г.Отгонбаатар/-д үүрэг болгосугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хувьцаа эзэмшигчдийн хурлын нарийн бичгийн дарга нарт тус тус үүрэг болгосугай.

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН ТӨЛӨӨЛӨГЧ

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМЫГ  
ТӨЛӨӨЛЖ:

Б.НАСАНТОГТОХ

УХА0558

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫГ  
ТӨЛӨӨЛЖ:

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

6096163 1118262

# "ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 04 сарын 26 өдөр

Дугаар № 06

Улаанбаатар хот

Компанийн эздийн өмч дэх төрийн  
өмчийн дүнг нэмэгдүүлэх, дүрэмд  
өөрчлөлт оруулах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1, 62.1.3, 62.1.16 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Дорнод аймгийн Дашбалбар сумын ОНӨААТҮГ-ын балансад бүртгэлтэй хавсралтад заасан 544,592,060.0 /таван зуун дөчин дөрвөн сая таван зуун ерэн хоёр мянга жаран төгрөг / төгрөгийн хөрөнгийн эх үүсвэрийн дүнгээр компанийн эздийн өмч дэх төрийн өмчийн дүнг нэмэгдүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. "Дорнод бүсийн эрчим хүчний систем" төрийн өмчит хувьцаат компанийн дүрмийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх заалтад "нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 508 256 274 ширхэг энгийн хувьцаатай" гэснийг 513 702 195 ширхэг энгийн хувьцаатай" гэж өөрчилсүгэй.

3. "Дорнод бүсийн эрчим хүчний систем" төрийн өмчит хувьцаат компанийн эздийн өмч дэх төрийн өмчийн дүнд орсон өөрчлөлтийг компанийн дүрэмд тусган холбогдох байгууллагуудад бүртгүүлэхийг Гүйцэтгэх захирал (Г.Отгонбаатар)-д даалгасугай.


4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хувьцаа эзэмшигчдийн хурлын нарийн бичгийн дарга нарт үүрэг болгосугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН  
ТӨЛӨӨЛӨГЧ


ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМЫГ  
ТӨЛӨӨЛЖ:

  
Б.НАСАНТОГТОХ  
УХА0558

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫГ  
ТӨЛӨӨЛЖ:

  
Ц.БАЯР-ЭРДЭНЭ  
6005169 ул. 11182621

"ДБЭХС" ТӨХК-ийн хувьцаа эзэмшигчдийн  
хурлын 2022 оны 4 дүгээр сарын  
26-ны өдрийн 06 дугаар тогтоолын  
хавсралт



**"ДБЭХС" ТӨХК-ийн эздийн өмч дэх төрийн өмчийн дүнгийн өөрчлөлт**

Д/д	Төрийн өмчийн дүн	Тогтоол шийдвэрийн дугаар	Бүртгэлийн дүн
1	2021 оны 01 дүгээр сарын 01-нээрх төрийн өмчийн дүн		50,825,627,452.43
2	Нэмэгдсэн: Дорнод аймгийн өмчийн газраас 573,775,886.00 төгрөгийн балансын үнэтэй 29,183,826.00 төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй 544,592,060.00 төгрөгийн үлдэгдэл өртөгтэй цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын тоног төхөөрөмж хүлээн авсан.	ТӨБЗГ-ын 2021 оны 10 дугаар сарын 19-ны өдрийн 431 дүгээр тогтоол	
3	Тайлан тэнцэлд тусгах төрийн өмчийн дүн		51,370,219,512.43
4	Нэрлэсэн үнэ		100
5	Хувьцааны тоо		<b>513 702 195</b>

# "ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 04 сарын 26 өдөр

Дугаар № 07

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус  
гишүүдийг чөлөөлж, томилох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, Авлигатай тэмцэх газрын 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 01/5918 дугаар дүгнэлтийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Дорнод бүсийн эрчим хүчний систем" төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд хараат бус гишүүнээр ажиллаж буй энэ тогтоолын нэгдүгээр хавсралтад нэр заасан гишүүдийг үргэжлүүлэн ажилуулахаар тогтоосугай.

2. "Дорнод бүсийн эрчим хүчний систем" төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд хараат бус гишүүнээр ажиллаж буй энэ тогтоолын хоёрдугаар хавсралтад нэр заасан гишүүдийг 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрөөр тасалбар болгон чөлөөлсүгэй.

3. "Дорнод бүсийн эрчим хүчний систем" төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус энэ тогтоолын гуравдугаар хавсралтад нэр заасан гишүүдийг 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрөөс эхлэн томилсугай.

4. Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг хуульд заасан хугацаанд гаргаж, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг судалж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдэд үүрэг болгосугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН  
ТӨЛӨӨЛӨГЧ

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМЫГ  
— төлөөлж:

*Б. Насантогтох*

Б. НАСАНТОГТОХ  
УХА0558

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫГ  
төлөөлж:

*Ц. Баяр-Эрдэнэ*

Ц. БАЯР-ЭРДЭНЭ

6098162 11102628


Хувьцаа эзэмшигчдийн хурлын  
2022 оны 04 дүгээр сарын 07 ний өдрийн  
07 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт



" ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ  
КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНЭЭР  
ҮРГЭЛЖЛҮҮЛЭН АЖИЛЛАХ ГИШҮҮДИЙН НЭРС

№	Хуулийн этгээдийн нэр	Гишүүн
1	" Дорнод бүсийн эрчим хүчний систем" ТӨХК	Д.Ган-Очир
2		Э.Эрдэнэхишиг

Хувьцаа эзэмшигчдийн хурлын  
2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн  
07 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралт



" ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ  
КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНЭЭС  
ЧӨЛӨӨЛӨГДӨХ ГИШҮҮДИЙН НЭРС

№	Хуулийн этгээдийн нэр	Гишүүн
1	" Дорнод бүсийн эрчим хүчний систем " ТӨХК	Г.Пүрэвдорж

Хувьцаа эзэмшигчдийн хурлын  
2022 оны 04 дүгээр сарын 28-ний өдрийн  
07 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралт



" ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ  
КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНЭЭР  
ТОМИЛОГДОХ НЭР ДЭВШИГЧДИЙН НЭРС

№	Хуулийн этгээдийн нэр	Гишүүн
1	" Дорнод бүсийн эрчим хүчний систем " ТӨХК	Э.Мөнх-оргил

# "ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 04 сарын 29 өдөр

Дугаар №08

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн  
өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдийг  
чөлөөлж, томилох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, Авлигатай тэмцэх газрын 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 01/5918 дугаар дүгнэлтийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Дорнод бүсийн эрчим хүчний систем" төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй энэ тогтоолын нэгдүгээр хавсралтад нэр заасан гишүүдийг үргэжлүүлэн ажилуулахаар тогтоосугай.

2. "Дорнод бүсийн эрчим хүчний систем" төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй энэ тогтоолын хоёрдугаар хавсралтад нэр заасан гишүүдийг 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрөөр тасалбар болгон чөлөөлсүгэй.

3. "Дорнод бүсийн эрчим хүчний систем" төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх энэ тогтоолын гуравдугаар хавсралтад нэр заасан гишүүдийг 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрөөс эхлэн томилсугай.

4. Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг хуульд заасан хугацаанд гаргаж, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг судалж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдэд үүрэг болгосугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН  
ТӨЛӨӨЛӨГЧ

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМЫГ  
ТӨЛӨӨЛЖ:

Б.НАСАНТОГТОХ

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫГ  
ТӨЛӨӨЛЖ:

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

6098169 11182020

Хувьцаа эзэмшигчдийн хурлын  
2022 оны 04 дүгээр сарын 28-ний өдрийн  
28 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт



"ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ  
КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛД ТӨРИЙН ӨМЧИЙН ТӨЛӨӨЛӨЛ  
ХЭРЭГЖҮҮЛЭХ ГИШҮҮНЭЭР ҮРГЭЛЖЛҮҮЛЭН  
АЖИЛЛАХ ГИШҮҮДИЙН НЭРС

№	Хуулийн этгээдийн нэр	Гишүүд
1	"Дорнод бүсийн эрчим хүчний систем" төрийн өмчит хувьцаат компани	Ж.Жанарбаатар
2		Г.Бадамцэцэг
3		Б.Энхтөр
4		В.Дарханбаатар



Хувьцаа эзэмшигчдийн хурлын  
2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн  
08 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралт



" ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ  
КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛД ТӨРИЙН ӨМЧИЙН ТӨЛӨӨЛӨЛ  
ХЭРЭГЖҮҮЛЭХ ГИШҮҮНЭЭР ТОМИЛОГДОХ  
НЭР ДЭВШИГЧДИЙН НЭРС

№	Хуулийн этгээдийн нэр	Гишүүн
1	" Дорнод бүсийн эрчим хүчний систем"	Г.Тулга
2	төрийн өмчит хувьцаат компани	Э.Жаргалмаа